ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ТӨААТҮГ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэсний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 261599, 321525

2024.12.09 № 245

танай ____________ -ны № ____________ -т

ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ж.ТАМИР ТАНАА

Тус байгууллагын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 34 хуудастай

ЗАХИРАЛ Ө.ЛУВСАНРЕНЧИН

1118272910 ... 5340659

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

*Төлөвлөгөөг хянасан:*
Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга ........................ (Ж.Тамир)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*(огноо)*
*Тэмдэг* ............................

*Төлөвлөгөө тайлагнасан:*
Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын захирал ........................ (Ө.Лувсанренчин)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*(огноо)*
*Тэмдэг* 2024.12.09

## "ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР" ТӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот Түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үйлчлүүлэгч байгууллага бүртэй байгуулсан гэрээний үүргийг бүрэн биелүүлж, харилцан үр ашигтайгаар урт хугацаанд хамтран ажиллах** | | | | | | | |
| 1. | **"Ажлын байрны хэвийн, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх"** зорилтын хүрээнд: | 7,081.5 сая төгрөг | Төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид ажил үүргээ хэвийн таатай орчинд гүйцэтгэх нөхцөлийг тогтмол бүрдүүлэн ажиллах. | Үйлчлүүлэгчдэд ISO 9001:2015 стандартын шаардлага хангасан үйлчилгээг тогтмол үзүүлэн ажилладаг. | ISO 9001:2015 стандартад нийцэх үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлэхдээ тэдгээрийн сэтгэлд нийцсэн байхаар ажилласан байх. | Үйлчлүүлэгчид ажил үүргээ хэвийн таатай орчинд гүйцэтгэх нөхцөлийг хангах хүрээнд агаар сэлгэлт, гэрэлтүүлэг, ус, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээ зэрэг цогц асуудалд тогтмол анхаарч, хяналт тавин ажилласнаар хэрэглэгчдээс гомдол гаргахгүй, сэтгэлд нийцсэн үйлчилгээг нь бүрэн үзүүлэн ажиллалаа.<br>Үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнг хэрэглэгч үйлчлүүлэгчдээр үнэлүүлэхэд сэтгэл ханамжийн түвшин 85,9 хувиар "хангалттай" түвшинд үнэлэгдсэн. | 100% |
| 1.1 | Цэвэрлэгээ үйлчилгээний ажил гүйцэтгэх | 4,342.7 сая төгрөг | ISO 9001:2015 стандартад нийцсэн цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлэх | Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын шаардлага хангасан | Стандарт, хэмжил зүйн газраас жил бүр хийдэг төлөвлөгөөт шалгалт /ISO 9001:2015/-нд | "Кю сертф" ХХК-аас 2024 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд хийсэн давтан баталгаажуулалтын аудитын шалгалтаар том, жижиг үл тохирол илрээгүй бөгөөд ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тул ISO 9001:2015 гэрчилгээ, тэмдэглэгээг хэрэглэх эрхийг 3 жилээр буюу 2021-2024 онд дахин үргэлжлүүлэн эзэмших эрх авсан. | хангалттай үнэлгээ авч, үргэлжлүүлэн эзэмшсэн байна. Тухайн стандартад нийцүүлэн цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэж ажиллана. | гэж аудитын баг дүгнэсэн тул ISO 9001:2015 гэрчилгээ, тэмдэглэгээг хэрэглэх эрхийг 3 жилээр буюу 2024-2027 онд үргэлжлүүлэн эзэмших эрх авсан.<br>Улмаар харьяа Засгийн газрын байруудад байрлах төрийн байгууллагуудад үзүүлж буй нийтлэг үйлчилгээг олон улсын чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001:2015)-нд нийцсэн хэлбэрээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан. | |
| 1.2 | Эрүүл ахуйн хяналт, ариутгалын үйлчилгээ хийж ажиллах. | 7,1 сая төгрөг | Монгол Улсад бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан бодисоор, технологийн горимийг хангасан ариутгал, халдваргүйтгэл хийх | 65015,2 м.кв талбайд халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл (дулааны шугам сүлжээ болон бусад байдлаар гаднаас мэрэгч, шавж зэрэг амьтад дамжих, үүрлэх эрсдэл тулгардаг)-ийг хийж ажилладаг. | Бүх өрөө, тасалгаанд халдваргүйтгэл, ариутгал, шавьжийн устгал /65015,2 м.кв/ хийж эрүүл, цэвэр, аюулгүй орчин бүрдүүлсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Жагсаалт батлах тухай" А/42, А/52, А/71 дүгээр тушаалаар баталсан халдваргүйжүүлэх бодисоор харьяа байруудын бүх талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг өдөр тутамд болон долоо хоног бүр хийхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар эцсийн халдваргүйтгэл, ариутгал, шавьжгүйтлийн устгалыг 14,487 метр квадрат талбайд, хортон мэрэгчгүйтгэлийн устгалыг 9,602.05 метр квадрат талбайд, хөгц, мөөгөнцерийн устгалыг 66.51 метр квадрат талбайд, нийт 24,155.56 метр квадрат талбайд мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн ажиллав. Мөн сард нэгээс доошгүй удаа 66338.41 метр квадрат талбайг өөрсдөө ариутган ажиллаж, шаардлагатай талбайд хортон шавьж устгалын бодисыг байрлуулан ажиллаж байна. Ингэснээр аливаа халдварт өвчнөөс үйлчлүүлэгчдийг урьдчилан сэргийлэх, ажлын байранд шавьж, мэрэгч амьтан үүсэх, үүрлэх нөхцөлийг арилгаж, ажилтнууд эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 1.3 | Цай визитийн үйлчилгээгээр үйлчлэх | 25,0 сая төгрөг | Эрүүл мэндэд тустай 43,628 аяга цай, 21,508 аяга кофе, 3,173 аяга аарц, чацаргана, ус зэрэг бүтээгдэхүүнээр үйлчилж, эрүүл аюулгүй байдлыг | Стандартын дагуу зочид, үйлчлүүлэгчдэд 25,402 аяга цай, 7,783 аяга кофе, 7,764 аяга аарц, чацаргана, ус зэргээр тогтмол үйлчилдэг | Цайны үйлчилгээний NUG-S-006 стандартад нийцсэн үйлчилгээг хэрэглэгчдэд тогтмол хугацаанд хүргэн ажиллах | Засгийн газрын II, III, IV, VIII, XII, XIII байруууд болон Соёлын яаманд цайны үйлчилгээг NUG-S-006 стандартын дагуу үзүүлж нийт 41,508 аяга цай, 18,819 аяга аарц, чацаргана, ус, 18,888 аяга кофег шуурхай соёлч боловсон, эрүүл ахуйн шаардлага хангасан хэлбэрээр технологийн дагуу үзүүлэн ажиллав. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ханган ажиллах | | | | |
| 1.4 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэг, ногоон байгуууламжийг арчлан хамгаалж, тарьж ургуулах. | 13,0 сая төгрөг | Ургуулж буй 3,145 ширхэг цэцэг, 10,764 метр квадрат талбайг зүлэгжүүлэх болон 80 цэцгийн мандал зэргийг байгуулсан, арчлан хамгаалсан эсэх; | Харьяа байруудад 3,145 ширхэг цэцэг арчилж, 10764 метр квадрат талбайд зүлэгжүүлж, 109 цэцгийн мандалд цэцэг тарьж ургуулдаг. | Гадна, дотор талын ногоон байгууламжийг арчлан ажилласнаар ашигтай, хүний эрүүл мэндэд тустай цэцгийн нэр төрөл, мод зэргийн тоо хэмжээ нэмэгдэж, орчны тохижилт сайжирсан байна. | Засгийн газрын харьяа байруудын өрөө тасалгаан дахь 3,145 ширхэг цэцгийг арчлан хамгаалж тохижилтыг сайжруулан ажиллав.<br>Гадна талбайд 5600 ширхэг шар хуайс шинээр тарьж, бусад бут сөөгөнд шохойдолт хийж, тайрч засаж сэргээн, 109 ширхэг цэцгийн мандалыг арчлан хамгаалж, 1865 ширхэг мандлын цэцгийг шинээр тарьж ургуулав. Хаврын улиралд буюу 4, 5 дугаар сард гадна талын ногоон байгууламжийг цэвэрлэн, гадна талбайн 10,764 метр квадрат ногоон байгууламжийн талбайн үржил шимгүй болсон хөрсөнд хар шороо цацаж, 2 кг цэцэгний үр, 1 кг зүлэгний үрээр бордож, хог ургамлыг устгаж, орчныг цэвэрлэн, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор өвс ногоог тэгшлэн хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 1.5 | Нийтлэг гардаг зарим хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, зохистойгоор хаяж зөөвөрлөсөн байх | --- сая төгрөг | Байруудад хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах хогийн савыг хийж байршуулан, зохистойгоор хаяж зөөвөрлөсөн байх | 2023 онд 14 байранд хог ангилан ялгах сав байрлуулж, зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр нийтлэг хог хаягдлыг зөөвөрлөдөг. | Харьяа 14 байранд төмрийн хог хаягдлыг ангилж ялган, цуглуулах дадлыг хэвшүүлж, нийтлэг гардаг хог хаягдлыг зөвшөөрөл бүхий байгууллагаар тээвэрлэж ажиллах;<br>Төмрийн хог хаягдлыг холбогдох дахин боловсруулах аж ахуй нэгжид нийлүүлэн ажиллах. | Харьяа 14 байранд ангилан ялгах хогийн савыг өөрсдийн нөөц боломжийг ашиглан хийж байрлуулан ажиллахын зэрэгцээ ажилчдаар дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ялгуулах сургалтанд хамруулан, түүнийг мөрдөн ажиллаж байна.<br>Улмаар барилга /төмөр, мод, цонх, шал, дрож, гэрэл/-ын хог хаягдлыг зарим өрөө тасалгаанд дахин ашигласнаар хөрөнгө мөнгө хэмнэж ажиллав. | 100% |
| 1.6 | Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэн ажиллах | 10,2 сая төгрөг | Цэнэггүй болсон галын хорыг тухай бүрт нь 100 хувь цэнэглэсэн эсэх;<br>"Гал түймэр, газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах тухай" сэдвээр сургалт зохион байгуулсан эсэх; | Галын хорын даралтыг тогтмол шалгаж, даралтгүй болох үед нь тухай бүр дахин цэнэглүүлж ажилладаг.<br>Харьяа байруудын ажилчдад "Газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах бэ?" сэдвээр бодитоор үзүүлэх сургалтыг | Даралтгүй болсон галын хорыг тухай бүрт нь цэнэглэж ажиллана.<br>Орчин үеийн дэвшилтэт хэлбэрийн гал унтраах хэрэгслэлийг байруудад байрлуулна.<br>Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж | Харьяа байруудад тавигдсан галын хорны даралтыг сар бүр үзэж шалгах замаар 100% цэнэглэж ажиллав. Үүнд: 15 ширхэг галын хор цэнэглэж, галын хорны бүслүүр тогтоогч (4 кг) 80 ширхэг, 4 кг-ын галын хор мөн 80 жирхэг, аваарын гэрэл 80 ширхэг, галын сарай хоосон 1 ширхэг, галын сарай иж бүрэн 1 ширхэгийг тус тус шинээр авч суурилуулан ажиллав.<br>Галын анхан шатны багаж хэрэгсэлд үзлэг хийн галын сарайн комыг шаардлагатай газарт нь 2 ширхэгийг байрлуулав. Жил бүрийн бүх нийтийн бэлэн байдлыг хангах, гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төрийн ордны онцгой байдлын албатай хамтран зохион байгуулдаг. | ажиллана. | дадлага сургуулилтыг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цагт болох үеэр харьяа байруудад байрлаж байгаа байгууллагуудыг хамруулан ажилласан.<br>Мөн ГБХНХЯ-тай хамтран тус салбарын ажилчдыг бүрэн хамруулсан сургалтыг байгууллага дээр хамтран хийж ажилласан. | |
| 1.7 | Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол хангаж ажиллана. | 1,496.7 сая төгрөг | Цахилгааны үр ашигтай, найдвартай ажиллагааг жил бүр сайжруулан ажилласан байх. | Харьяа байруудын цахилгааны далд монтажийн 70.0 хувь нь ашиглалтын шаардлага хангахгүйгээс галын аюултай байдлын түвшинд байна. Мөн цахилгааны утас болон өрөө тасалгааны гэрэлтүүлэх хэрэгсэл хуучирч, элэгдэж муудсан.<br>Иймд тогтмол хугацаанд засвар үйлчилгээний ажил хийдэг. | Цахилгаан хангамжийн тоноглолын ашиглалтын хэвийн ажиллагааг хангаж ажилласнаар үйлчлүүлэгчид жилийн турш цахилгаан хангамжаар найдвартай хангагдан ажилласан байх. | 1. Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Засгийн газрын XI (СЕХ) байранд дизель генератор суурилуулж, АВР (нөөцийг автомараар сэлгэн залгагч) аваарын тохиргоо хийж бэлэн байдлыг хангаж ажиллав.<br>2. Засгийн газрын II байр "Б" корпусын 3-р давхрын хурлын танхимыг албан өрөө болгон тохижуулсантай холбоотойгоор 1 дүгээр давхрын хүчний хуваарилах самбараас провод 10 ММ² хөндлөн огтлолтой кабелиар тусад нь тэжээл татан 50х60х20 самбар угсран цахилгааны монтажийг бүрэн шинэчлэв.<br>3. Засгийн газрын II байр (АҮЭБЯ)-ын дотор цахилгааны монтажийг хүчитгэх ажлыг хийж гүйцэтгэв.<br>4. Засгийн газрын II байр (СЯ)-ын автогражид цахилгаан машин цэнэглэгч суурилуулж холболтыг хийв.<br>5. Засгийн газрын III байрын кофе шопийг өөр өрөөнд нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой хуучин самбарыг зөөж холбогдох монтажийг хийж гүйцэтгэсэн.<br>6. Засгийн газрын III байрын цайны өрөөний монтажийг бүрэн шинэчилж, самбарыг угсрав.<br>7. Засгийн газрын VIII байранд аянга хамгаалал газардуулгын ажлыг хийж гүйцэтгэв. Мөн үзельд байрлах цахилгааны монтажийг шинэчлэв.<br>8. Засгийн газрын XII байрыг цахилгаан эрчим хүчээр хангадаг хаалттай дэд өртөөнд байрлах дөрвөлжин гал хамгаалагч шатаж байрны цахилгаан фаз дутуу ирж байсныг засварлаж хэвийн болгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.<br>9. Засгийн газрын XII байр (АМГТГ)-ын цахилгааны ерөнхий оролтын АВР (нөөц тэжээлийг автоматаар сэлгэн залгагч)-тай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | самбар угсарч суурилуулсан.<br>10. Засгийн газрын XII байр (Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам)-ын цахилгааны ерөнхий оролтын АВР (нөөц тэжээлийг автоматаар сэлгэн залгагч)-тай самбар угсарч суурилуулав.<br>11. Засгийн газрын XII байр (ГЗБГЗЗГ)-ын серверийн өрөөний 3-н фазын хүчдэл тогтворжуулаглагчид үзлэг үйлчилгээ хийн фазын ачааллыг тэнцүүлсэн. | |
| 1.8 | Ус, дулаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол ханган ажиллана. | 719,1 сая төгрөг | Ус, дулааны шугам сүлжээний тоноглолд засвар үйлчилгээний ажил хийж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангасан байх. | Ус, дулааны шугам хоолой, насос, бойлер зэрэг хэрэгслэлүүд моралын элэгдэлд орсноос шалтгаалан шинэчлэх шаардлагыг эрх бүхий байгууллагаас тавьдаг. | Харьяа байруудын үзельд элэгдэж муудсан халуун усны ялтсан бойлер, халуун усны автомат, халаалтын нөөц насос зэргийг суурилуулан, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан байх. | 1. Засгийн газрын II байр (АҮЭБЯ)-ын 1-р давхрын албан өрөөний хуучин паар цоорч гэмтсэн тул шинээр панелан паараар шинэчлэж, халаалтын шугамны ф20 хаалтууд хаагдахгүй байсныг шинээр солив.<br>2. Засгийн газрын II байр (АҮЭБЯ, ГБХНХЯ) -ын халуун усны насос эвдэрсэн тул шинээр солив.<br>3. Засгийн газрын II байр "А" корпусын цэвэр болон халуун усны төв магистраль шугам задарч, хэсэгчлэн цоорсон тул ф100 шугамаар шинэчилж засварласан.<br>4. Засгийн газрын III байр (ҮСТ, БШУЯ) болон II байр (СЯ)-ын нийт 15 өрөөний халаалтын колекторын ф25 хаалтуудыг сольж сайжруулав.<br>5. Засгийн газрын III байрын галын гидрантын хаалтууд барихгүй болсон тул 11 ширхэгийг шинээр сольж янзлав.<br>6. Засгийн газрын III байрын үзельд төв халаалтын шугам зэвэрч, цоорч муудсаныг шинээр солив.<br>7. Засгийн газрын IV байрын 1-ээс 3-р давхар, VIII байрын 1-ээс 2 дугаар давхруудын бүх албан өрөөнүүдийн халаалтын ф15 болон ф25 шугамнуудыг шинээр сольж суурилуулсан. Мөн тус байрын үзельд байрлах халаалтын насос, 1 дүгээр давхрын нийтийн эзэмшлийн талбайн галын гидрантын шугамыг тус тус шинэчлэв.<br>8. Засгийн газрын VIII байрын гадна дулааны цэвэр усны төв шугам цоорсоныг хэсэгчлэн сольсон.<br>9. Засгийн газрын IX байрын гадна төв халаалт, цэвэр усны шугам нь цоорч муудан, ус алдах эрсдэлтэй болсон тул шинээр солив. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10. Засгийн газрын IX "А" байрын үзельд байрлах монометр болон термометрийг тус тус шинэчлэв.<br>11. Засгийн газрын XI байрын бохирын шугам болон халаалтын шугамны ф15 хаалтуудыг шинээр сольж суурилуулав. Мөн тус байрын гадна байрлах дулааны төв худгийг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-аас сольж сайжруулан ажилласан.<br>12. Засгийн газрын XII байрын В1 давхарт байрлах халаалтын өгөх болон буцах шугамны ф25 хаалтыг шинэчлэв.<br>13. Засгийн газрын XIII байрын 3 дугаар давхрын албан өрөөнд тус тус 4 ширхэг ф15 хаалт, ф15 хий авагч шугамыг шинээр солив.<br>14. Засгийн газрын XIII байрын үзельд байрлах цэвэр усны тоолуур болон дулааны туузыг шинэчлэв.<br>15. Соёлын яамны үзельд байрлах монаметр болон термометрыг тус тус шинээр суурилуулж, халуун усны бойлерын ф50 изгоныг шинэчлэв.<br>16. Соёлын яамны үзельд байрлах халаалтын нэмэлт усны ф15 тоолуур шинэчлэв. Мөн төв шугамны буцах шугам зэвэрч цоорсон тул шинээр суурилуулах зэргийг ажлыг хийж гүйцэтгэв. | |
| 1.9 | Барилга, засвар мужааны үйлчилгээг хийж гүйцэтгэх | 451,4 сая төгрөг | Байгууллагаас тавьсан хүсэлт болон ерөнхий хэрэгцээ шаардлагад үндэслэн барилгын засварын ажил хийх | Өрөө тасалгааны өнгө үзэмжийг жил бүр засаж сайжруулан засвар үйлчилгээг хийдэг | Элэгдэж муудсан дээвэр, ариун цэврийн болон албан өрөө, тасалгаа зэрэг нийтдээ 30-аас доошгүй өрөө, талбайд засвар тохижилтын ажил хийнэ. | Байгууллагуудаас ирсэн хүсэлт, албан бичигт үндэслэн нийт 61 албан өрөөнд урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Засгийн газрын II "А" байрын дээврээс борооны ус дотогш нэвтэрч шатны хонгил болон зарим өрөө тасалгааны өнгө үзэмжийг муутган хана таазны өнгө шарлаж, замаска ховхорсонг засварлав.<br>2. Засгийн газрын II "Б" байр (Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв)-ын коридорт чиптэй шилэн хаалга, хана хийсэн. Тус давхарт байрлах 202 тоот цайны өрөөг засварлаж тохижуулан хүлээлгэн өгөв.<br>3. Засгийн газрын II "Б" байр (Аюулгүй байдал судалгааны хүрээлэн)-ын 117 тоот буюу цайны өрөө, Үндэсний итгэмжлэлийн төвийн 301 тоот өрөө, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ТӨААТҮГ-ын архивын өрөөнүүдийг тус тус засварлав.<br>Засгийн газрын II "Б" байрын 301 тоот, "Г" корпусын 201, 201а, 301в, 119, тоот өрөөнүүдэд өнгө сэргээх засварын ажлыг хийж гүйцэтгэв.<br>4. Засгийн газрын II "Г" байрын 301 (А, Б, В), 317 тоот өрөөнүүдийг яамнаас ирсэн албан бичгийн дагуу засварлаж тохижуулан хүлээлгэн өгсөн. Мөн тус байр (Засгийн газрын хүний нөөцийн газар)-ын 00, 202, 402, 411 тоот өрөөнүүдийг засварлав.<br>5. Засгийн газрын II байр "Г" корпусын өргөтгөлийн хэсгийн гадна пасадны хэсэг нь олон жилийн хугацаанд муудаж моралын элэгдэлд ихээр орж, зарим хэсгээрээ нурж түүгээр нь дотогш борооны ус нэвчин орж дотор заслыг эвдэлж, мөөгөнцөр үүсэх шалтгаан болсон учир гадна пасадыг гаднаас нь нягт сайтай хөөсөнцөрөөр бүрж, тор татан замаска татаж эмульсэдсэн. Үүнтэй холбоотой тухайн хэсгийн дээврийн төмрийг сольж шинэчилсэн.<br>6. Засгийн газрын II байр "Е" корпусын барилгын суултын улмаас 901 тоот өрөөний гадна пасадны шил хагарсаныг өндрийн кран ашиглаж хатаалттай давхар шилээр сольсон. Тус яамнаас албан бичгээр ирсэн хүсэлтийн дагуу 304, 808, 101, 108, 502, 505, 301, 303 тоот өрөөнүүдийг засварлаж хүлээлгэн өгөв.<br>7. Засгийн газрын III байр (Үндэсний статистикийн хороо)-ын 2-р давхрын нийтийн эзэмшлийн талбай болон бүх албан өрөөнүүдийн засварын ажилд тендер шалгаруулалт зарлаж шалгарсан мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэн засварлаж хүлээлгэн өгсөн.<br>8. Засгийн газрын IV байр (Санхүүгийн зохицуулах хороо)-ын зарим албан өрөө болон нийтийн эзэмшлийн талбайг засварлаж тохижуулан хүлээлгэн өгөв.<br>9. Засгийн газрын IX "Б" байрын дээвэр нь эвдрэлд орсоны улмаас дээврийн гөлмөн төмөр зэвэрч муудан цоорч дотогш борооны ус нэвчин орж дусаал дусаж байсныг хэсэгчилэн засварлаж хэвийн болгосон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10. Засгийн газрын VIII байрын 201 а,б тоот өрөөг иж бүрэн засварлав. Тус барилгын дэргэдэх төв замыг засаж 50 см өргөн болгож байгаатай холбогдуулан явган замыг мөн адил 50 см-ээр татах ажлыг хийж гүйцэтгэв.<br>11. Засгийн газрын XI байр (ЭЗХЯ)-ын гарцын схем, 207 тоот хурлын заалыг иж бүрэн засварлав.<br>12. Засгийн газрын XI байр (СЕХ)-ын цайны өрөөг бүрэн засварлаж хүлээлгэн өгсөн.<br>13. Засгийн газрын XII байрын 208 тоот өрөө болон шатны хонгилыг засварлаж хүлээлгэн өгөв. АМГТГ-ын 406 тоот өрөөг иж бүрэн засварлав.<br>14. Засгийн газрын XII байр (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам)-ын зарим хэсэг нь Ус цаг уур, орчны шинжилгээний газарт нүүж орж байгаатай холбогдуулан тус барилгын 3-р давхрын ариун цэврийн өрөө болон 308, 309а, 309б, 302, 306а, 306б тоот өрөөнүүдийг засварлаж хүлээлгэн өгөв.<br>15. Соёлын яамны барилгын дээвэр дээр гарах ямар нэгэн шат байхгүй байсан учир стандартад нийцсэн зориулалтын төмөр шат шинээр хийж гүйцэтгэсэн. Соёлын яамны сайдын өрөөний дусаал гоожиж шарласан таазыг сэргээн засварлав. Төрийн нарийн бичгийн даргын өрөөнд шинээр төмөр рам зангидаж дуу тусгаарлагч акустик хавтангаар доторлож гүйцэтгэв.<br>16. Засгийн газрын XIII байрын 7 өрөөнд нийт 14 ширхэг 3 давхар шилтэй, 72 мм рамтай вакум цонх сольж шинэчилсэн зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. | |
| 1.10 | Лифт болон агаар сэлгэх хэрэгслэлийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана. | 16,3 сая төгрөг | "Лифт, агаар сэлгэлтийн хэрэгслэлийг аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтлан осол авааргүй ажилласан байх. | Лифтэнд сар бүр мэргэжлийн байгууллагаар үзлэг шалгалт хийлгэж гарсан зөрчил дутагдлыг засаж ажилладаг. | Мэргэжлийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийг мөрдөн ажилласнаар аюул, осол гаргахаас урьдчилан сэргийлж ажилласан байх. | Засгийн газрын II, III, IX "А", XI байрын хүн зөөврийн лифтний хонгилын хаалга, кабин, худагт гоожсон тос, резенүүдийн бохирдлыг арилган, редукторын тосыг сольсон.<br>Засгийн газрын II байрын "Д" корпуст 4, "Е" корпуст 1, III байранд 1, IX байрын "А" корпуст 1, XI байранд 2, нийт 9 удаа лифтнүүдийг тус тус магадлалд оруулсан.<br>Засгийн газрын III байрын хүн зөөврийн лифтний гадна дуудлагын плат шатсаныг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчлэв.<br>Лифт ашиглалтын цаг үеийн үзлэг оношлогоог тухай бүр хийж, хяналт тавин ажиллав.<br>Тухайлбал лифтэнд нийт 18, агааржуулалтын чиглэлээр 6 дуудлага тус тус ирүүлснээс тухай бүрт нь алдаа, гэмтэл саатлыг түргэн шуурхай арилган ажиллаж, харьяа байруудад агааржуулалтыг хийж, сэлбэн засаж, хяналт тавин ажиллав. | |
| 2. | **"Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хангах"** зорилтын хүрээнд: | 82,9 сая төгрөг | Ажилтан, албан хаагчдыг ажлын байран дээр суралцах, хөгжих боломж, хамгаалах нөхцөлөөр хангах | Хүний нөөцийн бүрдэлт, сургалт, хөгжүүлэлтийг тогтмол хийж ажилладаг. | Чадварлаг, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчинг хөгжүүлж, хүний нөөцийн манлайллыг хөгжүүлж ажиллана. | Байгууллагын эрхэм зорилго, зорилтыг биелүүлэх чадвартай хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хийх хүрээнд албан хаагчдыг сонгон шалгаруулж ажилд авах, ажлын байранд сургаж дадлагажуулах, ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх, хариуцлага тооцох ажлыг цогцоор нь хийж ажиллав. | 100% |
| 2.1 | Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлыг хангаж ажиллах | 5,7 сая төгрөг | Хөдөлмөрийн аюул осолгүй ажиллах. | Ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй байдлын осол бүртгэгдээгүй. | Хүний эрүүл мэндэд хамгийн бага сөрөг нөлөөтэй бараа материал, багаж хэрэгсэл ашиглан, сургалт хөгжүүлэлтийг тогтмол хийж ажиллах. | Хуучнаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын "Лабораторын шинжилгээний дүгнэлт" болон Стандарт, хэмжил зүйн газраас баталгаажуулдаг "Үл тохирлын гэрчилгээ"-гээр баталгаажсан хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, чанарын шаардлага хангасан бараа материал, багаж хэрэгслэлийг худалдан авч, тасралтгүй ханган ажилладаг. Мөн харьяа байруудын нийт ажилчдад ажлын байран дээр нь хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөгөө мэдээлэл, сургалтыг Хууль, эрх зүй гэрээ хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөр хамгааллын инженерээр өгүүлж ажиллав.<br>ХАБЭА-н менежментийн тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой, хууль эрх зүйн болон бусад шаардлагын талаар мэдлэг олгоход чиглэсэн сургалтыг MNS 4969:2000 стандартын дагуу дараах сургалтанд хамруулав. Үүнд:<br>- Байгууллагын нийт ажилчдыг хамарсан байгууллагын батламжтай сургалтанд 240 ажилтан;<br>-Эрсдэлтэй ажлын байрны сертификаттай сургалтанд (өндрийн аюулгүй ажиллагаа) 24 ажилтан;<br>- ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх батламжтай сургалтанд 14 ажилтан, албан хаагчдыг "Ололт амжилтын түлхүүр" сургалтын төвтэй хамтран зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулав.<br>Улмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам, Аялал зугаалгаар явах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, Гамшгийн аюулгүйн байдлын тухай журмыг тус тус шинээр боловсруулан мөрдөн ажиллав.<br>Үйлчилгээний ажилчдын ажлын ачааллыг хөнгөвчлөх, эрүүл аюулгүй байдлыг хангах, шинэ дэвшилтэт багаж хэрэгслэлийг сонгож, техникийн ажилчдын бохирын хувцас 7 ширхэг, өндрийн бүс 10 ширхэг, гагнуурын хувцас 2 ширхэг, нүд хамгаалах хэрэгсэл 10 ширхэгийг стандартын шаардлага хангасан батламж бичигтэй ажлын хувцасыг олгосон. | |
| 2.2 | Хүний нөөцийн бүрдэлт, сургалт хөгжүүлэлт, шагнал урамшууллыг хийж ажиллах | 63,7 сая төгрөг | Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, сургаж, хөгжүүлэх, тусалж дэмжих | Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, сургаж тусламж дэмжлэг үзүүлдэг. | Хүний нөөцийн бүрдэлтийг ил тод, нээлттэй хийж, ажлын байран дээр сургаж, тусламж дэмжлэг үзүүлсэн байх. | Байгууллагын вэб сайт, Хөдөлмөрийн бирж, СХД, БЗД, СБД, ЧД-тэй хамтран хүний нөөцийн бүрдэлтийг хийж ажиллав. Шинээр ажилд орж буй ажилтанг гурав хүртэлх сараар туршилтаар ажиллуулах хугацаанд нь практикийн сургалт мэдээлэлд хамруулж, зөвлөгөө өгч ажилласны үндсэн дээр 28 ажилтанг Захирлын зөвлөлийн хурлаар цаашид үндсэн ажилтнаар ажиллуулахаар шийдвэрлэн ажиллав. Ажилчдын санал хүсэлтийг хүлээн авч холбогдох дүрэм, журмын хүрээнд өндөр насны тэтгэвэрт гарсан 8 ажилтанд нийлбэр дүнгээр 38,2 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэв. | 100% |
| 2.3 | Дотоод аудит, хяналт шинжилгээ, хууль, эрх зүй, чанар стандартыг хангах үйлчилгээ | 13,5 сая төгрөг | Байгууллагын үйл ажиллагаа хууль, стандартын хүрээнд явагдаж, хяналт шинжилгээ хийгдэж байх. | Жил бүр Стандарт, хэмжил зүйн газрын шалгалтанд хамрагдаж, гадна болон доторх аудитын шалгалт хийгддэг. | Байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын дагуу явуулж ажилласан байх | Нийтээр дагаж мөрдөгдөх хууль тогтоомж болон байгууллагын дүрэм журмыг баримтлан ажиллах явцад тогтмол хяналт тавин ажиллав.<br>Шаардлагатай тохиолдолд төр засгийн гаргасан хууль тогтоомжид үндэслэн байгууллагын дотор мөрдөгдөх дүрэм журмыг шинэчлэх, жишиг байдлаар хэрэгжүүлэх ажлыг цаг алдалгүй хийн ажиллав.<br>Мөн байгууллагын дотоод хяналт шалгалтаар бараа материалын анхан шатны баримтын бүрдэлтэнд хийсэн хяналтын ажил, сар бүр олгодог нормын бараа материалын зарцуулалтанд хийсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт шалгалтын ажил, харьяа байруудын цэвэрлэгээ үйлчилгээний хяналт шалгалтын ажил, нэмэгдэл цалин хөлс бодолтонд хийсэн хяналт шинжилгээний ажлуудыг тус тус хийж гүйцэтгэв. Улмаар байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын ажлын хүрээнд үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилт болон тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шалгалтын ажлыг үргэлж хийж гүйцэтгэсэн. | |
| 3 | **"Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх"** зорилтын хүрээнд: | 23,7 сая төгрөг | Туршлага судалж, шинэ арга барил, технологийг нэвтрүүлэх | 2023 онд дотоодын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын засвар үйлчилгээний үйл ажиллагааг интернэтээс судалж, туршлага судлан ажилласан. | Нийтлэг үйлчилгээний ажлын талаарх давуу болон сул тал, ашиглагдаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, арга туршлагыг харилцан солилцон ажилласан байх; | Ижил төстэй үйл үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй харилцан уулзалт зохион байгуулан, туршлага судлан ажиллав. Улмаар байгууллагын үндсэн үйл ажиллагаанд тохиромжтой шинэ, чанартай ажлын багаж хэрэгслэл (аюулгүй ажиллагааны хувцас г.м), үйлчилгээний нэр төрөл (автомашины зогсоолын зохицуулалт), арга барил (2-3 үйлчлэгч багаар хамтарч албан өрөөг цэвэрлэх)-ыг нэвтрүүлэн ажиллав. | 100% |
| 3.1 | Төрийн байгууллагад үзүүлдэг нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор гадаад улсын болон дотоодын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах; | 23,7 сая төгрөг | Дотоод болон гадаадын нэгээс доошгүй байгууллагатай хамтран ажиллаж, харилцан туршлага солилцон ажилласан байх; | Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил үйл ажиллагаа явуулдаг дотоодын (Uniservice, Рийч пойнт ХХК)- туршлагыг судлан ажиллав. Улмаар засвар үйлчилгээ, аюулгүй байдал, ногоон байгууламж болон бусад чиглэлээр судалж мэдээллийн бааз үүсгэн ажилласан. | Гадаад болон дотоодын нэгээс доошгүй байгууллагуудтай шинээр харилцаа холбоо тогтоож, харилцан үр ашигтай хамтран ажилласан байх; | Хариуцсан ажлаа сайн гүйцэтгэж буй ажилчдыг урамшуулах, идэвхжүүлэх зорилгоор чанарын 19 багаас төлөөлж буй 42 ажилтан, албан хаагчдыг дотоодын "Түнхэл Тур" амралтын баазад 2 хоногийн хугацаанд харилцан туршлага солилцож, цаашид ажил үйлчилгээг улам сайжруулах сургалтанд хамруулан ажиллав. Жил бүр ажилчдын дунд зохион байгууллагддаг ажил мэргэжлийн уралдаанд эрхэлсэн ажилаараа бусдыгаа тэргүүлэн ажилласан 17 ажилчдыг БНХАУ-ын Жинин, Ордос, Хөх хотуудад 7 өдрийн аялалд хамруулсан. Энэхүү ажлын үр дүнд цэвэрлэгээ үйлчилгээ, аюулгүй байдал, ногоон байгууламж зэрэг чиглэлээр ойлголт мэдэгдэхүүн авав. | 100% |
| 4 | **"Санхүү, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг удирдан ажиллах"** зорилтын хүрээнд: | 7,7 тэрбум төгрөг | Орлогоороо санхүүжиж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх. | Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажилладаг. | Хөрөнгө санхүүгийн хувьд үйл ажиллагаагаа хэвийн санхүүжүүлж ажилласан байх. | Үйлдвэрийн газар нь явуулсан үйл ажиллагааныхаа үр дүнгээр өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллав. 2024 онд төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллав. | 100% |
| 4.1 | Төсөв хөрөнгийг төлөвлөгөөт хэмжээнд төвлөрүүлж, үр ашигтай зарцуулж ажиллана. | 7,7 тэрбум төгрөг | Өмнөх оны мөн үед олох төлөвлөгөөт орлогоос тухайн оны мөн үед олох | 2023 онд 6,8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан. | Орлогыг нэмэгдүүлж, зарцуулалтын үр ашигтай хийсэн байх. | Тус үйлдвэрийн газар нь тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагааны орлогоороо санхүүжигдэн ажилладаг. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орлогыг бууруулахгүй ажиллах; | | | 2024 онд 7,7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллав. | |
| 4.2 | Өмч хөрөнгийн менежментийг сайжруулан ажиллах | ---- | Өмчийн бүртгэл тооллого, ашиглалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байх | ТӨБЗГазраас төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэхэд биелэлт 95%-тай буюу "хангалттай" гэж үнэлсэн. | Төрийн өмч хөрөнгийн бүртгэл, тооллого хийж, ашиглалтыг сайжруулан, эд хөрөнгийн ямар нэг зөрчилгүй ажилласан байх. | Тайлант хугацаанд байгууллагын эд хөрөнгийн үзлэг, тооллогыг хийж гүйцэтгэн, тайлан мэдээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав.<br>Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх чанар, загвар, шаардлагад нийцсэн эд хөрөнгийг бүртгэн, сэлбэн засаж сайжруулан, үргүй зардал гаргахгүй байх талаар анхаарч ажиллав. Улмаар бараа материал, сэлбэг хэрэгслэлийн хадгалалт, төрөлжүүлэлт, цэгцлэлтийг боловсронгуй болгож, бэлэн байдлыг ханган ажиллалаа. | 100% |
| 4.3 | Харьяа байруудад байрлах төрийн байгууллагуудын байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний чиглэлээр улсын төсөвт тусгуулан батлуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажлын тооцоо судалгааны төсвийн саналыг боловсруулж, тухайн байгууллагуудад хүргүүлэн ажиллах; | --- | Харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах болон хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажилласан эсэх | Харьяа байруудад байрлаж үйл ажиллагаа явуулж буй 81 /Ажил, нийтлэг үйлчилгээ гүйцэтгэх-36, түрээс-12, граж-12, бусад-21/ байгууллагатай гэрээ байгуулсан. | Харьяа байруудад байрлан ажилладаг төрийн байгууллагуудад байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний ажлын чиглэлээр ирэх жилийн төсөвт ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын ажил тусгуулах шаардлагатай тухай саналыг хүргүүлж ирэх онд хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцсэн байх. | Засгийн газрын байранд байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын эзэмшиж байгаа байр, талбай, авч байгаа нийтлэг үйлчилгээний хэмжээнд ногдох зардлыг тухайн байгууллагын төсөвт суулган санхүүжүүлж байхаар заасны дагуу 2025 оны улсын төсөвт тусгуулах шаардлагатай байр ашиглалтын зардлын саналыг харилцагч байгууллагуудад 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 48-85 дугаар тоот албан бичиг 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 122-158 тоот албан албан бичгээр тус тус хүргүүлсэн. | 100% |

----- x -----

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Хавсралт №1-ийн биелэлт

1118272010 ... 5340669

## Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ажилчдын дунд 2024 онд хийгдэх сургалтын төлөвлөгөөний биелэлт

| № | Сургалтын нэр | Сургалтын зорилго | Хугацаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| **Нэг. Ажлын байран дахь сургалт** | | | | |
| 1. | Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалт | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах | I улирал | Тус сургалтанд 24 ажилчдыг хамруулж, сертификаттай болсон. Улмаар ажлын байран дээр ажлын байрны үзлэг шалгалт хийх, аюулыг олж илрүүлэх, эрсдлийг үнэлэх, хяналтын үр дүнтэй аргыг хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлж ажиллав. |
| 2. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/370 тоот тушаалд заасан нийт ажилтан, албан хаагчдын сургалт | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах | I улирал | ХАБЭА-тай холбоотой зайлшгүй дагаж мөрдөх хууль эрх зүйн болон бусад шаардлагын талаар мэдлэг олгоход чиглэсэн батламжтай сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "Ололт амжилтын түлхүүр" сургалтын төвтэй хамтран 240 албан хаагчдын дунд зохион байгуулан ажиллав. |
| **Хоёр. Мэргэшүүлэх, дадал эзэмшүүлэх сургалт** | | | | |
| 1. | Цэцэг, ногоон байгууламжийн үйлчилгээ | Ургамал арчлах арга арчилгаанд суралцах | II, III улирал | Нийт үйлчлэгч болон бусад ажилтнуудад тасалгааны болон мандлын цэцэг арчлах, тарих, бордох, тайралт хийх ба мод хэлбэржүүлэлтийн талаарх зөвлөгөө мэдээллийг байр тус бүр дээр хийж ажилласан. |
| 2. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт | Хууль тогтоомжийн дагуу ажиллах | Жилдээ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн сургалтанд албан хаагчдыг хамруулж, 5 ажилтан хамрагдаж 2 ажилтан гэрчилгээ /АЗ/ эзэмшсэн. |
| 3. | Онцгой байдлын газартай хамтран гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт | Гамшиг осол, галын аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, чадвар дадал суулгах | II улирал | Улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулагддаг "Гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах" тактикийн сургалтанд байгууллагын нийт ажилчид болон харьяа байруудад байрладаг яам, агентлаг, төрийн байгууллагууд, тэдгээрийн албан хаагчдыг хамруулж, заавар зөвлөгөө өгч ажиллав.<br>Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам) гамшгаас хамгаалах бэлэн байдлын команд штабын сургуулийг Засгийн газрын II байранд 2024 оны 11 дүгээр сарын 11-12 ны өдрүүдэд зохион байгуулахад хамтран ажиллаж, байр ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллалаа. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | Лифтчний аюулгүй ажиллагааны төлөвлөгөөт сургалт | Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | II улирал | Хүний нөөцийн дутагдлаас хамаарч тогтвор, суурьшилтай ажилтанг сургахаар тус сургалтыг 2025 онд зохион байгуулахаар хойшлуулав. |
| 5. | Цахилгаанчин, мужаан, сантехникч нарын мэдлэг, ур чадвар дээшлүүлэх сургалт | Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх | III улирал | Шинээр ажилд орсон техникийн ажилчдад хариуцсан инженер болон хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженерээр мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллуулдаг. |
| 6. | Хөргөлт, агаар сэлгэлтийн сургалт | Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | II улирал | Бүх салбарт нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан ажиллах хүчин буурч, байгууллагын хүний нөөцийн дутагдалтай байгаагаас хамаарч хойшлуулсан. |
| 7. | Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох сургалт | Мэргэжлийн өндөр ур чадвартай татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ бүхий харилцааг төлөвшүүлэх | III улирал | Татварын ерөнхий газрын Нэмэгдсэн өртгийн албан татвар, ААНОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт, буцаан олголтын талаарх сургалтанд 5 ажилтан хамрагдсан. |
| 8. | Мэргэшсэн үйлчлэгчийн сургалтанд хамруулах | Стандарт хэрэгжүүлэх, ажиллагчдад мэргэжил, дадал суулгах | II улирал | Шинэ, залуу боловсон хүчин ажлын байран дээр тогтвортой, удаан ажиллах нь нийгэмд нийтлэг байгаатай холбоотойгоор тухайн сургалтыг хойшлуулахаар шийдвэрлэсэн. |
| 9. | Цай зөөгчийн мэргэшүүлэх сургалт | Цай зөөгч нарт мэргэжил, дадал суулгах | III улирал | --- |
| **Гурав. Мэргэжил олгох сургалт** | | | | |
| 1. | Мэргэжил дээшлүүлэх сургалт | Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх | Жилдээ | Ажилтан, албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр мэргэжил дээшлүүлэх тохиолдолд дэмжин ажиллав. |
| **Дөрөв. Сургалтанд үзүүлэх бусад дэмжлэг** | | | | |
| 1. | Суралцах боломжийг хангах үүднээс ажлын хуваарийг өөрчлөх, чөлөө олгох | Ажилтны нийгмийн баталгааг хангахад туслах | I, III улирал | Их, дээд сургууль болон мэргэшүүлэх сургалтын төвд хамрагдсан ажилтнуудыг тухайн сургалтанд суух цагт нь чөлөө олгон улмаар нөхөж ажиллуулах, бусдаар ажлыг нь гүйцэтгүүлэх хэлбэрээр ажилладаг. |
| **Тавь. Туршлага судлуулах** | | | | |
| 1. | Шинэ ажилтныг дадлагажуулах буюу чиглүүлэх сургалтууд | Ажлын байранд дадлагажуулах, арга барил эзэмшүүлэх | Улирал бүр | Чанарын багийн ахлагч, инженерүүд болон холбогдох албан хаагчид шинээр ажилд орсон ажилчдад ажлын байрны тодорхойлолтонд заагдсан чиг үүргээ гүйцэтгэхэд нь чиглүүлэлт хийж ажиллав. |
| 2. | Чанарын багуудын тэргүүн туршлагыг солилцуулах, нэвтрүүлэх | Тэргүүн туршлага нэвтрүүлэх, багийн ажлыг идэвхжүүлэх | IV улирал | Хариуцсан ажлаа сайн гүйцэтгэж буй ажилчдыг урамшуулах зорилгоор чанарын 19 багаас төлөөлж буй 42 ажилтан, албан хаагчдыг дотоодын "Түнхэл Тур" амралтын баазад 2 хоногийн хугацаанд харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулав.<br>Чанарын багууд цахим хуудас, фэйсбүүкийн фэйж хуудаснаас бусад байруудын хийж байгаа ажлын мэдээллийг цаг тухай бүрт хүлээн авч туршлага солилцон ажиллав. |

----- x -----

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Хавсралт №2-ийн биелэлт.

## “Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлт

| Хэрэгжүүлэх хөтөлбөрийн төрөл | Агуулга | Хэрэгжүүлэх үндэслэл | Төрөл |
|---|---|---|---|
| 1. Ажилтан, ажиллагчдыг ажиллах нөхцөлөөр хангах | 1.1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт; | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам, Гамшгийн аюулгүйн байдлын тухай журмыг тус тус шинээр боловсруулан мөрдөн ажиллав. Мөн байр тус бүрийн цахилгаанчинд 5 ширхэг батерей дриль, сантехникчдэд бохирын хувцас 7 ширхэг, өндрийн бүс 10 ширхэг, гагнуурын хувцас 2 ширхэг, нүд хамгаалах хэрэгсэл 10 ширхэгийг болон стандартын шаардлага хангасан батламж бичигтэй ажлын хувцас олгон ажиллав. |
| 2. Нийгмийн баталгааг хангах | 2.1. Хоол, унааны хөнгөлөлт үзүүлнэ. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт; | Нэг ажилтны хоол, унааны хөнгөлөлтөнд зориулж ажлын нэг өдөрт 8,000 төгрөг олгоход нийт 411,5 сая төгрөг зарцуулсан. |
| | 2.2. Орон байраар хангах, амьдрах нөхцөлийг нь сайжруулах | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт; | Харьяа байруудад барилгын дотор засварын ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор тухайн байранд дахин ашиглахад тохиромжгүй болсон зарим эд зүйлсийг Өмч хамгаалах, үнэ тогтоох комиссын шийдвэрээр олгож ажилладаг. |
| | 2.3. Сургалтын төлбөр олгох | Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт; | Төсөвчин бэлтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг мөрдөн ажиллах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах эрх олгох зэрэг сургалтанд албан хаагчдыг хамруулснаар байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломж нөхцөл бүрдэн ажиллав. |
| 3. Нэмэгдэл баталгаа | 3.1. Ажил албан тушаалыг хэвээр хадгалах. | Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйл; | Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан ажил албан тушаалыг хэвээр хадгалах тухай заалтыг чанд мөрдөн ажилладаг. |
| | 3.2. Ажилтан, албан хаагчдад үзүүлэх хөнгөлөлт | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт | Байгууллагын ажилтнуудын нийгмийн тулгамдаж буй асуудлаар судалгаа авч боловсруулан байгууллагын захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 тоот тушаалаар ЗГБНҮГ-ын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах тусгай хөтөлбөр (2022-2025 он)-ийг боловсруулан мөрдөн, хэрэгжүүлэн ажилладаг. |

| | | | |
|---|---|---|---|
| 4. Цалин хөлс | 4.1. Албан тушаалын цалин, мэргэшлийн зэрэг цол, ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт | Ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажил үүргээ чанартай гүйцэтгэдэг шалгуурыг харгалзан сард дунджаар 89 ажилтанд 1-12 сард нийт давхардсан тоогоор 1068 ажилтанд 139,5 сая төгрөг олгов. Илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 1-12 сар хүртэл 29,9 сая төгрөг зарцуулав.<br>Мөн ажилласан хугацаагаар удаан жилийн нэмэгдэл цалинг олгоход 146,4 сая төгрөг, ээлжийн амралтаа авсан ажилчдад 310,7 сая төгрөг, техникийн ажилчдын шөнийн нэмэгдэлд 21,5 сая төгрөгийг тус тус зарцуулав.<br>Оны эцэст түлээ нүүрс, халаалт дулааны хөнгөлөлт болон үр дүнгийн урамшууллыг зохих журмын хүрээнд олгов. |
| 5. Ахмадын дэмжлэг | 5.1. Тэтгэвэр тогтоолгох | Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.5, дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 9 дүгээр зүлийн 9.3.10 дахь заалт | 2024 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэрт гарсан 8 ажилтанд 6 сар хүртэлх үндсэн цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний тусламж олгоход зориулж 38,2 сая төгрөг зарцуулав. |
| | 5.2. Тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд тусламж олгох | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль 8.5 дахь хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам 9 дүгээр зүйлийн 9.3.6 дахь заалт; | Олон улсын Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан үе үеийн ахмадуудаа хүлээн авч Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-1 ахмад, Монгол Улсын Төрийн дээд шагнал Алтан гадас одон медалийг-2 ахмадад гардуулж, нийт 110 ахмадуудад гарын бэлэг хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд: 17,3 сая төгрөг зарцуулав.<br>Мөн Сар шинийн баяр (Билгийн тооллын хаврын эхэн сарын шинийн нэгэн)-ыг тохиолдуулан 120 ахмад настанд нийт 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| 6. Тэтгэмж, тусламж | 6.1. Албан хаагчийн гэр бүлд гачигдал тохиолдвол тусламж олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь зааль; | Ар гэрт нь гачигдал гарсан 28 ажилтанд нийлбэр дүнгээр 7,5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн. |
| 7. Шагнал урамшил | 7.1. Мөнгөн шагнал олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журам 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт; | --- |
| | 7.2.Төрийн дээд байгууллага болон Засгийн газрын шагналд тодорхойлох | Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох журам" | Сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагад үр бүтээлтэй, өндөр амжилт гаргасан ажилчдад төрийн дээд шагнал "Алтангадас" одонг 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 13, салбарын хүндэт тэмдэгээр 8 ажилтан, салбарын жуух бичгээр 2 ажилтанг тус тус шагнав. Мөн Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны өдрийг тохиолдуулан хамт олноо манлайлан ажилласан ажилтан, албан хаагчдыг Төрийн дээд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | шагнал Алтан гадас одон медалийг-1, Хөдөлмөрийн хүндэт медаль-13, салбарын хүндэт тэмдгээр 18, салбарын жуух бичгээр 10 ажилтанг тус тус шагнасан. |
| 8. Эрүүл мэнд | 8.1. Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдах, үйлчилгээ авах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйл | Байгууллагын нийт албан хаагчдыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд түргэн шуурхай үзүүлж, эмчлүүлдэг байх зорилгоор Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулан ажилладаг.<br>Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд 124 ажилчид хамрагдаж улмаар өдрийн эмчилгээнд хамруулав.<br>Цус сэлбэлт судлалын Үндэсний төвтэй хамтран "Бусдын төлөө цусаа өгч амьдрал бэлэглэе" уриан дор байгууллагуудын нийт 60 гаруй ажилчид сайн дурын ажилд хамрагдав.<br>Мөн байгууллагын болон харьяа байруудад байрлан үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн нийт ажилтан, албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын II, III байруудад эмнэлгийн анхан шатны үзлэг буюу яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж ажиллав.<br>Засгийн газрын II байрын спорт зааланд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн мэргэжлийн багшаар ажилчдад гар бөмбөгийн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. |

----- x -----